

ЮАН УЛСЫН СУДАР
СОНИНЫ МЭДЭЭНИЙ ДУРСГАЛ БОЛОХ НЬ

ц. Чойсамба*, Ч. Халиун**

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, доктор.
** МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн оюутан.

Түлхүүр үг: бичлэгийн төрөл, зүйл, мэдээ, мэдээнд тавигдах шаардлага, 5W&1H.

Мэдээ бол сэтгүүл зүйн амин сүнс, цөм нь юм. Тогтмол хэвлэлийн бичлэгийн төрөл, зүйлүүд мэдээнээс эх үүсвэртэй бөгөөд түүнээс салбарлан гарсан байдаг. Тиймээс ч судлаачид мэдээг "сэтгүүл зүйн зүрх" гэж тодорхойлсон байдаг билээ¹.

Дэлхий дахинд мэдээг сэтгүүл зүйн бичлэгийн хамгийн эртний зүйл гэж үздэг байна. Мэдээ нь анхандаа хүмүүсийн хооронд амнаас ам дамжин улмаар бичгээр болон бусад аргаар тардаг байжээ. XX зууны дунд үеэс мэдээ нь шинжлэх ухааны ойлголт болон төлөвшсөн байна.

Манай орны хувьд мэдээ хэмээх энэхүү бичлэгийн зүйл эртний уламжлалтай юм. Манай тогтмол хэвлэлд мэдээ гүнзгий нэвтэрч өөрийн дүр төрхөө нэгэнт олсон хэдий ч түүнийг бичиж байсан үндэсний уламжлалын талаар судалгаа бараг хийгдээгүй билээ. Гэтэл мэдээ нь үндэсний бичиг соёлын өв уламжлалтай нягт холбоотойгоос гадна монгол бичгийн хэлний найруулгын арвин баялаг өвийг уламжилсан шинжтэй байдаг байна².

Монгол орон мэдээ бичлэгийн нэн эртний уламжлалтай юм. Түүний нэг тод жишээ нь Юан улсын судрын он дарааллын мэдээнүүд болно. Энэхүү судар нь монгол бичгээр таталгасан гар бичмэл бөгөөд нийт 211 дэвтэр бөгөөд Монгол гүрэн Хятадыг эзэрхээд, улмаар Бээжинг нийслэл хотоо болгон төвлөж байх үеийн цадиг түүх бөлгөө. Үүнээс тус түүхэн сурвалжийн хорин дөрөвдүгээр дэвтэр буюу "1312 оны бичиг"-ийг сонгон авч, сонин мэдээний чанартай зүйлст ажиглалт хийлээ.

Уг бичиг нь 1312 оны үед Юан улсын төр засгаас баримталж байсан бодлого шийдвэр, хэрэгжүүлж байсан арга хэмжээ, тухайн үеийн ард олны аж байдал, байгаль цаг уурын элдэв үзэгдлийн баримтыг өдөр өдрөөр нь багцлан тэмдэглэсэн мэдээний цуглуулга юм.

Энэхүү мэдээний хураангуйг Мин улсын бичгийн утгач, бичгийн дэд сайд бөгөөд дэс дундад тайву өргөмжлэх зарлигийг даасан улсын судрыг хавсран зохиогч Сун Ляан найруулав гэж судрын өмнөтгөлд дурджээ.

Уг бичгийг задлан шинжлэхийг зорилоо.

Шинжлэх ухааны доктор Л.Норовсүрэнгийн тэмдэглэснээр, "Мэдээ бол сэтгүүл зүйн анхны

бичлэгийн зүйл бөгөөд улс төрийн утга агуулга, нийгмийн оюун санааг илэрхийлэхэд чиглэсэн тодорхой зорилготой байдаг. Сэтгүүл зүйн ухааны үүднээс мэдээг олон түмэнд зориулсан нийгмийн ач холбогдол бүхий үйл ажиллагаа гэж үздэг³.

Юан улсын судрын 1312 оны мэдээ нь одоогоос 692 жилийн тэртээ буюу дэлхий дахинд сэтгүүл зүй үүсэхээс өмнө бичигдсэн хэдий ч мэдээний мөн чанар, орчин цагийн мэдээнд тавигддаг үндсэн шаардлагуудыг өөртөө агуулж чадсан нь нэн сонирхолтой юм.

Мэдээ бол сонины бичлэгийн мэдээллийн төрлийн хамгийн шуурхай хэлбэр.

Иймээс мэдээнд товч, тодорхой, түргэн шуурхай, үнэн зөв байх гэсэн үндсэн дөрвөн шаардлагыг тавьдаг⁴.

Гэтэл Юан улсын судрын 1312 оны бичиг нь сонин хэвлэл үүсэхээс өмнө бичигдсэн атлаа тогтмол хэвлэлийн мэдээний бичлэгийн дээрх шаардлагыг тодорхой төвшинд хадгалж чадсан нь гайхалтай юм.

Өөрөөр хэлбэл аль 1312 оны үед монголчууд мэдээ хэмээх бичлэгийн зүйлийг ашиглаж улс орондоо болсон чухал үйл явдлуудыг өдөр өдөрт шуурхай тэмдэглэн үлдээсэн нь асар үнэтэй юм.

Бусад бичлэгийн төрөл зүйлээс ялгарах мэдээний гол онцлог нь товч байх бөгөөд эн тэргүүнд энэхүү шаардлагыг Юан улсын судрын хорин дөрөвдүгээр дэвтэр бүрэн хадгалж чадсан байна. Тухайлбал: "Цагаагчин хонь өдөр засгийн хэргийг туслан мэдэгч түшмэл Хиуй

Сан улсын хөвгүүдийн сургуулийг данслан засуулав" (96-р тал), "Харагчин могой өдөр бурханы үйлс үйлдээд хорьсон ялтан хорин есөн хүнийг тавив" (32-р тал), "Харагчин тахиа өдөр Шау Нин Хүньюу дор тэмээ гучин зургааг хүртээв" (25-р тал), "Хөхөгчин гахай өдөр тэрэг морин шанду дор халив" (18-р тал), "Харагчин хонь өдөр түшмэл гаргаж хамгаалах цэргийг сонгож байлгав" (52-р тал), "Хөх бичин өдөр улсын хөвгүүдийн яамнаа утгыг эрхлэх асар байгуулав" (12-р тал) гэх мэтээр бичжээ.

Эдгээр нь өнөөгийн сонины "ганц өгүүлбэрээр" хэмээх боолтонд ордог товч мэдээнүүд байна. Үүнээс

үндэслэн тогтмол хэвлэлийн бичлэгийн зүйл болох мэдээг товч бичих явдал нь олон зууны тэртээгээс уламжлагдан ирсэн гэж үзмээр байна.

Уг сурвалжууд бас мэдээнд тавигддаг тодорхой байх шаардлагыг хангасан байна. Тухайлбал: "Улаан хулгана өдөр үнийг хорогдуулж нийслэлийн сангийн амууг өдөр бүр мянган таар худалдаж үгээгүү иргэдэд түгээв" (20-р тал), "Есөн сарын улаагчин тахиа өдөр Хяан За муж дор далайгаар зөөх амуу хорин түмэн таар нэмэв" (17-р тал), "Улаагчин могой өдөр олон монгол иргэдийн үгээгүү ядуу дор, сангийн амууг гарган туслагтун хэмээв" (31-р тал) гэжээ. Үүнээс харахад мэдээг тодорхой болгохын тулд зохиогч элдэв зүйлийг нэмж тайлбарлаагүй харин ч нэг бүхэл санааг аль болох цөөн үгээр илэрхийлэн гаргасан.

«

Өөрөөр хэлбэл аль 1312 оны үед монголчууд мэдээ хэмээх бичлэгийн зүйлийг ашиглаж улс орондоо болсон чухал үйл явдлуудыг өдөр өдөрт шуурхай тэмдэглэн үлдээсэн нь асар үнэтэй юм.

»

Мөн Юан улсын судрын 1312 оны бичиг нь мэдээний түргэн шуурхай байх чанарыг хангасан гэж үзэж болохоор байна. Учир нь уг мэдээг хөтлөгч Мин улсын бичгийн утгач, бичгийн дэд сайд бөгөөд дэд дундад тайву өргөмжлөх зарлигийг даасан улсын судрыг хавсран зохиогч Сун Ляан улс орондоо болж өнгөрсөн үйл явдлыг цаг алдалгүй өдөр өдрөөр нарийвчлан бүртгэж тухайн өдөр болсон онцлох үйл явдлуудыг түүвэрлэн бичсэнээрээ шуурхай чанарыг агуулсан байна. Тухайлбал: "Таван сарын хөхчин үхэр өдөр хаан Тайнхугийн лүгээ тэнд Үйцүн дор уулзаад хөх бичин өдөр Үйцүн сууринд сууж зургаан сарын харагчин могой өдөр зарлигаар хаан дор алтан эрдэнэ хүртээжээ. Дөрвөн зүг дор илч илгээж ном бичгийг нийтээр эрж хасыг сийлж, тамга хуудас болгон тэмдэглээд шадар түшмэл дор тушааж бариулжээ" (9-р тал), "Гурван сарын цагаан луу өдөр урьд дэд түшмэл Со Ми, То Ли түшмэл нарыг дуудаж нийслэл хотод хүрч ирүүлээд олон хөгшин түшмэл лүгээ хэргийг хэлэлцэгтүн хэмээв" (34-р тал), "Шарагчин гахай өдөр зүүн гар, баруун гар дор түшмэд нижгээд нэмж тавив" (40-р тал) гэжээ.

1312 оны бичиг нь мэдээний үнэн зөв байх шаардлагыг ч мөн хангаж чадсан болой. Юан улсын судрыг тэмдэглэсэн Сун Ляан улсын судрыг хавсран зохиогч байсан нь түүнээс тухайн нийгэм цаг үедээ болж байсан онцлох үйл явдал, төр засгийн шийдвэрийг эмхтгэн тэмдэглэхэд нэлээд дөхөмтэй байсан буй заа. Түүний хөтөлсөн энэхүү бичиг нь бодит баримтанд үндэслэсэн мэдээний хураангуй товчоон болж чадсан байна. 1312 оны мэдээ өөрөө түүхийн эх сурвалжийн зэрэгцээ үүнд тэмдэглэгдэн үлдсэн бичил

мэдээнүүд нь түүхийн бусад эх сурвалжаар баталгаажиг байгаа бөгөөд эдүгээ ч түүний үнэн бодитой баримтыг түүхийн өөр бусад эх сурвалжтай харьцуулан судалж болох юм.

Сонин хэвлэл байгаагүй, сонин мэдээ гэсэн нэр томъёог ч үүсээгүй байсан 1312 оны энэхүү сурвалж нь орчин цагийн сонин мэдээний үндсэн шаардлагыг өөртөө агуулж чадсанаас үзэхэд тогтмол хэвлэлийн мэдээний үндсэн шаардлагыг эртнээс улбаатай зүйл гэж үзэж болохоор байна.

Юан улсын судрын хорин дөрөвдүгээр дэвтэр буюу 1312 оны бичгийг хэлбэрийн үүднээс задлан шинжлэхэд нэг өгүүлбэрээс бүтсэн мэдээ дийлэнх хувийг эзэлж байгаа бөгөөд энэ нь товч тодорхой бичих шаардлага монголчуудын хувьд эртний уламжлалтайг харуулж байна.

Иймээс ч 1312 оны бичигт товч мэдээг үлэмж ихээр ашигласан бөгөөд тухайн өдөр болсон голлох үйл явдлын баримтыг дурдаад цөөн үгээр тайлбар хийх хэлбэр нэлээд зонхилж байна. Тухайлбал:

"Улаан барс өдөр олон цэрэг дор амуу долоон мянга бөгөөд жаран таар түгээв" (54-р тал), "Хөх морин өдөр зүүн, баруун хэлтэс ба журганы түшмэдийн ялыг уучлав" (19-р тал) гэжээ. Үүнээс харахад товч мэдээ нь аль нэг газар болсон баримтыг мэдээлсэн шинжтэй байсан нь ажиглагдаж байна.

Мөн 1312 оны бичигт өнөөгийн сонсгол мэдээтэй адилтгамаар зүйл нэлээд байгаа юм. Тухайлбал: "Хөхөгчин үхэр өдөр Ло Рогийн их ахмад гүнж Шинхар дор хааны эгч их ахмад гүнжийн цол дэвшүүлж нэмэв" (55-р тал), "Шарагчин гахай өдөр гэрэлтэй бичгийн хүрээний эрхэлсэн бичгийн даргыг засгийн

хэргийг туслан мэдэгч түшмэл болгов" (81-р тал) гэсэн байна. Энд хааны зарлиг тогтоол, шадар сайд түшмэдэд зэрэг дэв өргөмжлөх, бууруулах гэх зэргийн үйл явдлын тухай мэдээ зонхилж байгаа бөгөөд мэдээний энэ хэлбэр нь өнөөгийн сонсгол мэдээний онцлогийг өөртөө агуулж чаджээ.

Харин Юан улсын сударт өнөөгийн дэлгэрэнгүй мэдээний хэв маягийг хадгалсан мэдээ үгүй байна. 1312 оны бичиг нь тухайн жилд болсон үйл явдлуудыг мэдээлэх зорилгоор товч бичигдсэн, ямар нэг оршил төгсгөлийн үгийг зохиогч хийж өгөөгүй ажээ. Шинжлэх ухааны доктор Л.Норовсүрэнгийн тэмдэглэснээр, "Дэлгэрэнгүй мэдээ нь үйл явдлыг мэдээлэх явцдаа бага зэргийн оршил, төгсгөл хийж зохиогчийн товч дүгнэлтийг оруулсан байдаг" гэжээ⁵.

Ийм мэдээ ховор байгаагаас үзэхэд 1312 оны бичигт зохиогч дэлгэрэнгүй мэдээнээс илүүтэйгээр товч мэдээг голлосон гэж үзмээр байна.

Энэхүү 1312 оны мэдээг сэдэв агуулгын хувьд ангилж үзье.

Юан улсын судрын 1312 оны бичигт Юан улсын хаан харц ардын зовлонг биеэр гүйцэд мэдрэхийн тулд доордсын хоолыг идсэн тухайг зохиогч тэмдэглэхдээ: "Хаан цухалдахдаа буурцагт шингэн будаа иджээ. Их эр зовиурыг гүйцэд амсахгүй болбоос эгнэгт тарианы зовох зүдэхийг үл мэдэхийн тул амархан залхаж болмой хэмээгээд тушааж авч идэв" (5-р тал) хэмээснээс үзвэл уг мэдээ нь тухайн үед гаргаж байсан хааны цааз зарлигийг тэмдэглэсэн албаны шинжтэй мэдээ болжээ. Мөн "тарианы" гэсэн үгээр харц ядуу тариачин ардыг төлөөлүүлсэн байна.

Мөн Юан улсын сударт тэмдэглэхдээ: "Төрийн бичигч Шуубин гувчуурлаг хурааж давхар иргэнийг мухардуулмой хэмээж түүнээс ван Ву дор тушааж цагдан явж байцаагтун." (76-р тал) хэмээснээс үзвэл тухайн үед хаан төрийн хэргийг тэрсэлж амин хувийн олз ашгийн төлөө ард түмнийг төрийн нэрээр мөлжин дарлаж байсан харгис түшмэлүүдийг хатуу шийтгэж байсныг илтгэсэн байна.

Мөн ордон дотуур ван түшмэдүүд сэм хуйвалдаан зохиож их самуурлын үүдийг нээсэн тухай тэмдэглэхдээ: "Хаан өгүүлрүүн ван нар юунд энэ үгийг гаргамой. Тэдгээр муу ард дотуураа ордон дотор нийлж бидний гэрт самууныг үүсгэсэн тул цаазаар аваач гэв." (8-р тал) Үүнээс харахад мөн л шудрага бус загнасан ихэс түшмэлд хариуцлага тулгаж буй хааны зарлигийг хураангуйлан зохиогч мэдээ хэлбэрт оруулан бичжээ.

Мөн төрийн хэрэгт олон жил үнэнчээр зүтгэсэн ахмад сайд түшмэд нарыг цуглуулж төрийн хэргийг хэлэлцэж ярилцдаг байсан баримт байна. Тухайлбал, "Хар хулгана өдөр засгийн хэргийг боловсронгуй мэдэгч, угаас нэр алдар бүхий хөгшин түшмэл нарыг нийслэлд дуудаж хамт олноор төрийн хэргийг хэлэлцэв" (92-р тал) хэмээснээс тодорхой.

Мөн хаан шадар түшмэдүүддээ шагнал урамшуулал олгосон зарлиг зэргийг хураангуйлан мэдээлсэн мэдээ баримт нэлээд байна. Тухайлбал: "Элч илгээж баруун газрын хуврагууд дор алт таван мянган лан, мөнгө хоёр түм таван мянган лан, торго бөс гурван түм есөн мянга есөн зуун эн хүртээв" (94-р тал), "Шарагчин тахиа өдөр зарлигаар цэргийн хүнд хишиг хүртээв" (62-р тал), "Хөх хулгана өдөр умард цэрэг

дор торго бөс хорин түмэн агтыг өгөв", "Есөн сарын улаагчин тахиа өдөр Хяан За муж дор далайгаар зөөх амуу хорин түмэн таар нэмэв" (17-р тал), "Улсын багш дор цаасан вааюу түмэн хишиг хүртээж хуучин хотод сүм байгуулав" (58-р тал) гэснээс тодорхой болой. Мөн ард иргэд ч бас өөрийн хир хэмжээндээ таарсан тусламжийг цэргийн хүмүүст үзүүлж байсан баримтыг энэхүү 1312 оны бичигт тэмдэглэн үлдээсэн байна. Тухайлбал: "Найман сарын шар морин өдөр Юүн зуугийн Монгол цэргийн идэш ховор болсон дор өрх бүр амуу нэгэн таар өгөв." (156-р тал) гэжээ.

Мөн Юан улсын сударт бичиг эрдмийн холбогдолтой мэдээ баримт нэлээд ажиглагдаж байв. Тухайлбал: "Дотоод бичгийн Бин Зан түшмэл Лин Ман дор тушааж улсын хөвгүүдийн яамыг захируулан сургаж өгүүлсэн нь: сургуулийн яам хэмээгч хүний эрдэм үүнээс гарах тулд улсын сургуульд олон хүрч олон хүүхдийг сурган шалгаж, эрдэм ёсыг шаардагтун" (26-р тал) хэмээжээ. Үүнээс харахад хөвгүүдийг шалгаж бичиг эрдэмд хамруулах зарлигийг мэдээ болгон тэмдэглэжээ.

Юан улсын судрын 1312 оны мэдээний ерөнхий агуулга нь хааны гаргаж байсан зарлиг тушаалыг эмхтгэн тэмдэглэснээс гадна байгалийн элдэв үзэгдлийг тэмдэглэжээ. Тухайлбал: "Хар барс өдөр, нийслэл хот дор газар хөдлөв" (154-р тал), "Зургаан сарын шарагчин хонин шинэтгэл өдөр нийслэл хотод газар хөдлөв" (28-р тал), "Энэ Яан зэргийн газар дор салхин мөндөр болов" (89-р тал), "Харагчин хонь өдөр Ра зуу дор газар хөдөлж их салхин салхилан дуу нь аянга мэт бөлгөө" (66-р тал), "Хар бичин өдөр Ба Зуу ван Хяаны албан тариан дор усан зовлон

болсон тулд түшмэл илгээж нэвтрүүлэн шалгав" (104-р тал), "Хөх хулгана өдөр Нин Хяан дор газар хөдлөв" (46-р тал) гэх мэтээр бичжээ.

Мөн 1312 оны бичигт Юан улсын төр ард огноо дэмжин гусалж олон хэлбэрээр урамшуулдаг байсныг харуулсан мэдээ нэлээд ажиглагдав. Тухайлбал: "Хар луу өдөр нийслэлийн сангийн амууг гаргаж үнийг хорогдуулан худалдаж үгээгүй иргэн дор түгээв" (39-р тал), "Цагаан хулгана өдөр үнийг хорогдуулж нийслэлийн сангийн амууг өдөр бүр мянган таар худалдаж үгээгүй иргэн дор түгээв" (12-р тал), "Хөх хулгана өдөр нийслэл хотод зарлигаар амуу худалдах газар арван хоерыг байгуулав" (93-р тал), "Өдөр бүр шударгаар найман зуун таар худалдаж үгээгүй иргэнд түгээв" (74-р тал), "Дотоод цэрэг дор амуу хоёр мянган таар түгээв" (120-р тал) гэжээ.

Мөн Юан улсын судрын 1312 оны бичигт хаан төрөөс гаргаж байсан хориг цаазыг илэрхийлсэн мэдээ цөөнгүй байна. Тухайлбал:

"Цагаагчин туулай өдөр иргэний алтан цаас хийх ба алтыг хайлуулж алт нээхийг цаазлав" (39-р тал), "Улаагчин үхэр өдөр битгий хорт эмээр архи нэрэгтүн хэмээн цаазлав" (108-р тал) гэжээ. Үүнээс үзэхэд 1312 оны бичигт агуулагдаж байгаа мэдээ нь сэдвийн хувьд өргөн цар хүрээг хамарч чаджээ.

Юан улсын судрын хорин дөрөвдүгээр дэвтэрт нийтдээ 240 мэдээ тэмдэглэгдэн үлдсэн байна.

Дүгнэлт

Юан улсын судрын 1312 оны бичиг тэмдэглэгдэн үлдсэнээс хойш хэдийнээ 692 жил алсалжээ.

Энэхүү Юан улсын судрын хорин дөрөвдүгээр дэвтэр, 1312 оны үйл явдлыг хамрах бөгөөд бүтэн нэг

жил тойронд Юан улсын дотоод амьдралд болж байсан үйл явдал, хааны цааз зарлиг, ард олны амьдрал ахуй, байгалийн элдэв үзэгдлийн өөрчлөлтийн тухай өдөр өдрөөр тоймлон товч тодорхой бичиглэн үлдээжээ.

Монголд тогтмол хэвлэл зуу шахам жилийн тэртээ үүсэж хөгжсөн бөгөөд үүнтэй уяалдан мэдээний бичлэгийн төрөл зүйл буй болж төгөлдөржин хөгжсөн гэж үздэг. Тэгвэл одоогоос бараг 700 шахам жилийн тэртээ тэмдэглэгдэн үлдсэн Юан улсын сударт мэдээ хэмээх бичлэгийн зүйлийг хэрэглэдэг байжээ гэж дүгнэж болохоор байна.

Энэхүү 1312 оны бичигт тухайн цагийн байр байдал зохиогчийн тэмдэглэлээр тов-

чоологдсон бөгөөд үзэж харсан, сонсож дуулсан, бичиж тэмдэглэсэн тэргүүтэн нь олны хүртээл болох буяны үйлсийн бадар- аягыг дүүргэж өлзий билгийн энэхүү судар бичиг бидний үед уламжлагдан иржээ.

Энэхүү судар элдэв чамирхал гоё ганган үг хэрэглэн хэлбэрийг хөөлгүй бодит баримтанд тулгуурлан энгийн хүүрнэн өгүүлсэн хэдий ч хэл найруулгын хувьд уншихад нэлээд түвэгтэй байсныг энд тэмдэглэн хэлэх нь зүйтэй болов уу.

Судар бичигт газар нутаг гэх мэт байршил заасан ихэнх үгийг хятад дуудлагаар бичсэн нь нэлээд бэрхшээлтэй байв. Юан улсын судрын 1312 оны бичиг нь сонины мэдээний дурсгал мөн юм. Үүнд:

1. Эртний Ромын уран илтгэгч Марк Фабий Квинтилианы үеэс буюу

2000 жилийн турш 5W&1H гэсэн зургаан асуултанд хариулт өгснөөр үйл явдалын талаар бодит дүр зургийг буулгаж чадна гэж үздэг⁶ Тэгвэл Юан улсын судрын 1312 оны бичигт тэмдэглэгдэн үлдсэн мэдээнүүд нь сэтгүүл зүйн сонгодог зургаан асуулт гэгддэг 5W&1H буюу хэзээ, хаана, юу, хэн, яаж, яагаад гэсэн асуултанд хариулсан нь ихээхэн сонирхол татаж байгаа юм.

Тухайлбал: "Гурван сарын улаагчин барс өдөр, хаан хамгаалах цэргийг авч дотор оронд өвгөдийн гэрийн хуулийг самууруулав хэмээн тушааж түшмэлийг бариулаад шүүж асуусанд өчиг өгсөн тул шар луу өдөр цаазаар аваачив" (15-р тал) гэжээ. Энэ мэдээнээс хара-

хад, "Хэзээ" гэсэн асуултанд: гурван сарын цагагчин барс өдөр, "Хаана" гэсэн асуултанд: дотор оронд, "Юу" гэсэн асуултанд: түшмэлийг цаазлав, "Хэн" гэсэн асуултанд: хаан, "Яаж" гэсэн асуултанд: хамгаалах цэргийг авч, тушааж түшмэлийг бариулж асуусанд өчиг өгсөн, "Яагаад" гэсэн асуултанд: өвгөдийн гэрийн хуулийг самууруулав гэжээ.

2. Тэр үед мэдээг цаг алдалгүй тархаах суваг байгаагүй иймээс зөвхөн тэмдэглээд түүх болгон үлдээдэг байж. Хэрэв тэр үед сонин, радио гэх мэт хэвлэл мэдээллийн хэрэгсэл байсан бол 1312 оны мэдээнүүд хамгийн шуурхай мэдээ болох байжээ.

3. Юан улсын судар 1312 оны бичиг сэдвийн хувьд өргөн цар хүрээг хамарч чаджээ. Сэдвийг

«
Монголд тогтмол хэвлэл зуу шахам жилийн тэртээ үүсэж хөгжсөн бөгөөд үүнтэй уяалдан мэдээний бичлэгийн төрөл зүйл буй болж төгөлдөржин хөгжсөн гэж үздэг. Тэгвэл одоогоос бараг 700 шахам жилийн тэртээ тэмдэглэгдэн үлдсэн Юан улсын сударт мэдээ хэмээх бичлэгийн зүйлийг хэрэглэдэг байжээ гэж дүгнэж болохоор байна.
»

ерөнхийд нь төр засгийн, аж ахуйн, хууль цаазын, боловсролын, цэргийн, соёл урлагийн гэх зэргээр ангилж болохоор байна.

Эцэст нь мэдээ гэдэг бол зөвхөн сонин сэтгүүлийн үүсэлтэй холбоотой гарч ирээгүй юм. Энэ нь хэзээнээсээ хүн төрөлхтний харилцааны чухал хэрэгцээ байсан байна. Үүнийг мэдээ Занги солилцоо эгэл болхи хэлбэрүүд хүн үүссэний дараах үед ч байснаар тайлбарлаж болох юм.

Энэхүү тэмдэглэл судрыг уншиж шарласан хуудсыг эргүүлэхүйд хэний ч болов мэлмийг нээж, сонорыг мялаахаар эрдэнэ мэт мөрүүд элбэг байна.

Ном гэдэг толгойд буюу цээжинд байдаг, эрдэм гэдэг гарт байдаг чадлын нэр байсан аж. Одоо цагт "Номч бус" номтон олширсон болохоор "Ном" гэдэг үг нэлээд хөндийдүү сонсогдох болжээ.

"Монголчууд ном дор мөргөмүү" гэж ярьдаг нь туйлын учиртай. Сайн номд сүүлийн хуудас гэж байхаас эцсийн уншигч гэж үгүй. Энэ номыг гүйцэд судалбал тийм байх нь дамжиггүй.

Ишлэл

¹ Kessler L., McDonald D. *Uncovering the News*. Belmont. 1987. P. 1.

² Дэлэг Г. Монголын тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ. 1965. X. 23.

³ Норовсүрэн Л. Сонины бичлэгийн төрөл, зүйл. УБ. 1994. X. 15.

⁴ Чойсамба Ч. Сонины мэдээллийн бичлэгийн төрөл, зүйл. УБ. 2001. X. 25.

⁵ Норовсүрэн Л. Монголын тогтмол хэвлэлийн бичлэгийн төрөл, зүйл. УБ. 1996. X. 20.

⁶ Чойсамба Ч. Сонины мэдээллийн бичлэгийн төрөл. УБ. 2001. X. 12.

Ашигласан материалын жагсаалт

1. Дэлэг Г. 1965. Монголын тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ.
2. Норовсүрэн Л. 1994. Сонины бичлэгийн төрөл, зүйл. УБ.
3. Норовсүрэн Л. 1996. Монголын тогтмол хэвлэлийн бичлэгийн төрөл, зүйл. УБ.
4. Чойсамба Ч. 2001. Сонины мэдээллийн бичлэгийн төрөл. УБ.
5. Anderson D., Itule B. 1983. *Contemporary News Reporting*. New York.
6. Bard R. 1993. *News Writing Guide*. Washington.
7. Cohler D. K. 1990. *Broadcast News Writing*. Englewood Cliffs.
8. 1990. *Handbook for Journalists of Central and Eastern Europe*. Washington.
9. Kessler L., McDonald D. 1987. *Uncovering the News*. Belmont.
10. Mencher M. 1986. *Basic News Writing*. Iowa.
11. 1988. *News Reporting and Writing*. New York.
12. Ward H. 1985. *Professional News Writing*. Washington.

Резюме

В этой статье предпринимается попытка доказать, что хроника «Истории юанской династии», составленной почти семь веков тому назад, содержит элементы современной газеты, и, более того, отвечает требованиям, ныне предъявляемым к жанру информация. В частности, некоторые хроники дают ответы на классические вопросы 5W&1H.